

Монгол суралцагчдын үнэт зүйлсийг тодорхойлох судалгааны үр дүн

Халтарын Энхжаргал
Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Гомбын Баярмаа
Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Сэржмядагийн Цогбадрах
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Баярсайханы Батцэнгэл
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Энхбаярын Оюунчимэг
Боловсролын үнэлгээний төв

https://journal.mnier.mn

Санал болгож буй эшлэл:
Энхжаргал, Х., Баярмаа, Г., Цогбадрах, С., Батцэнгэл, Б., Оюунчимэг, Э. (2026). Суралцагчдын үнэт зүйлсийг тодорхойлох нь: Оролцогч талуудын судалгааны үр дүн. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, *31(2)*. https://doi.org/10.56380/mjer.v31.2.1

Khaltar Enkhjargal
Mongolian National University of Education

Gombo Bayarmaa
Mongolian National University of Education

Serjmyadag Tsogbadrakh
Mongolian National Institute for Educational Research

Bayarsaikhan Battsengel
Mongolian National Institute for Educational Research

Enkhbayar Oyunchimeg
Educational Evaluation Center

To cite this article:
Enkhjargal, Kh., Bayarmaa, G., Tsogbadrakh, S., Battsengel, B., Oyunchimeg, E. (2026). Research Findings on Identifying the Values of Mongolian Learners. Mongolian Journal of Educational Research, *31(2)*. https://doi.org/10.56380/mjer.v31.2.1

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Боловсролын судалгааны Монголын сэтгүүл MJER

2026, Vol. 31, No. 2 https://doi.org/10.56380/mjer.v31.2.1

Монгол суралцагчдын үнэт зүйлсийг тодорхойлох судалгааны үр дүн

Халтарын Энхжаргал, Гомбын Баярмаа, Сэржмядагийн Цогбадрах
Баярсайханы Батцэнгэл, Энхбаярын Оюунчимэг

Өгүүллийн мэдээлэл

Түүх:
Хүлээн авсан: 2026.06.08
Засаж сайжруулсан: 2026.09.30
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2026.11.27

Түлхүүр үг:
Суралцагч
Үнэт зүйлс
Чадамж
Үнэт зүйлийн боловсрол
Сургалтын хөтөлбөр

ХУРААНГУЙ

Үнэт зүйлд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчдыг нийгэмд эергээр хувь нэмэр оруулах хариуцлагатай, ёс зүйтэй, хариуцлагатай, амьдралын сорилтод бэлтгэгдсэн иргэн болгон төлөвшүүлэх чухал ач холбогдолтой болсоор байна. Энэхүү судалгааны зорилго нь сургуулийн удирдлага, багш, суралцагчдын үнэлгээнд тулгуурлан суралцагчдын үнэт зүйлсийг тодорхойлоход орших бөгөөд чанарын болон тоон судалгааны аргыг ашигласан. Судалгааны эхний шатанд мэдээллийг олон нийтийн дунд нээлттэй асуулгаар явуулсан ба нийт 10118 иргэдээс ирсэн өгөгдлийг шүүн, шаардлага хангасан 9000-г нь боловсруулж, оролцогчдын хамгийн их санал нийлсэн давтамжийн тоогоор 25 үнэт зүйлсийг сонгосон. Дараагийн шатанд тэдгээр 25 үнэт зүйлсийг 5 бүлэгт ангилан ЕБС-ийн 438 удирдах ажилтан, 871 багш, 1323 суралцагчаар Лайкертийн 5 хэмжээс бүхий асуулгаар үнэлүүлж, шинжилсэн. Судалгааны үр дүн нь үндэсний ижилсэл, хүнлэг чанар, бие даан суралцах чадвар, нийгмийн хариуцлага, шинжлэх ухааны сэтгэлгээг сургалтын хөтөлбөрт харилцан уялдаатай тусгах шаардлагатайг харуулж байна. Мөн үнэнч шударга, хариуцлага, хүлээцтэй байдал зэрэг үнэт зүйлс, зан чанарыг төлөвшүүлэх, зөв дадал хэвшил суулгах нь багш нарын хандлага, сургуулийн соёлыг бэхжүүлэх зэрэг хүчин зүйлсэд эергээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:
Х.Энхжаргал, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль
e-mail: enkhjargal@mier.mn

Research Findings on Identifying the Values of Mongolian Learners

Khaltar Enkhjargal, Gombo Bayarmaa, Serjmyadag Tsogbadrakh,
Bayarsaikhan Battsengel, Enkhbayar Oyunchimeg

Article information

Article history:
Received: 08.06.2026
Revised: 30.09.2026
Accepted: 27.11.2026

Keywords:
Learner
Value
Competence
Values education
Curriculum

ABSTRACT

Values-based education is therefore considered essential for developing responsible, ethically conscious individuals who are equipped to navigate life's challenges and contribute positively to society. This study aims to identify the values to be fostered among students based on assessments provided by school administrators, teachers, and students. This study employed a mixed-methods approach integrating qualitative and quantitative research. In the initial phase, data were collected through an open-ended public survey administered of the 10118 responses received, 9000 met the inclusion criteria and were retained for analysis. Based on the frequency of responses, 25 values were identified for further investigation. In the subsequent phase, these values were organized into five domains and assessed by 438 school administrators, 871 teachers, and 1,323 students from general education schools using a five-point Likert-type scale. The findings underscore the importance of systematically integrating national identity, humanistic values, self-directed learning, social responsibility, and scientific thinking into school curricula. Furthermore, fostering values and character attributes such as honesty, responsibility, and tolerance, alongside positive behavioral habits, may contribute to strengthening a supportive school culture and promoting values-oriented educational practices.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:
Enkhjargal.Kh, School of Educational Studies, Mongolian National University of Education
e-mail: enkhjargal@mier.mn

УДИРТГАЛ

Улс орнууд сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд, дээд боловсрол, цаашлаад насан туршийн боловсролын түвшинд XXI зууны суралцагчийн эзэмших чадамжийн хөгжилд анхаарал хандуулж байна. Чадамж нь нийгмийн оюун санааны нэгдмэл байдлыг хангаж, чиглүүлэх гол хүчин зүйл болох үнэт зүйлд суурилах бөгөөд суралцагчдын үнэт зүйлийг тодорхойлж, тусган хэрэгжүүлснээр хөтөлбөр цогц болно (Боловсролын хүрээлэн. 2021. х 90). XXI зууны боловсролын зорилго нь суралцагчид мэдлэг, чадвар эзэмшүүлэхээс гадна тухайн мэдлэг, чадвараа хувь хүн, нийгэм, хүрээлэн буй орчны өмнө хариуцлагатайгаар ашиглах үнэт зүйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэж байна. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн хувьд үнэт зүйл нь мэдлэг, чадварыг ямар зорилгоор, ямар зарчимд тулгуурлан хэрэглэхийг чиглүүлдэг суурь бүрэлдэхүүн болдог. Иймээс сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүй, үнэлгээний тогтолцоонд үнэт зүйлсийг уялдуулан тусгах нь боловсролын бодлого, хөтөлбөр судлалын чухал асуудал болж байна (OECD, 2021).

Монгол Улсын боловсролын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсролын зорилго, суралцагчийн хөгжил, чадамжийг нэгдмэл байдлаар тодорхойлсон (УИХ, 2023). Мөн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг цогцоор нь хөгжүүлэхийг онцолсон (МУЗГ, 2024). Үүний зэрэгцээ “Монголын боловсролын хувирган өөрчлөлт–2024” үндэсний чуулганаар боловсролын үнэт зүйлсийг дэлхийн соёл, хүн чанар, гэр бүл, суралцахуй, монгол сэтгэлгээ гэсэн чиглэлээр тодорхойлсон. Энэ нь үндэсний боловсролын онцлог, нийгмийн нийтлэг үнэт зүйл, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг сургалтын хөтөлбөрт тэнцвэртэй тусгах асуудлыг судалгааны түвшинд авч үзэх шаардлагыг бий болгож байна. Бодлогын баримт бичигт үнэт зүйлсийг тодорхойлох нь чухал боловч тэдгээрийг суралцагчдад төлөвшүүлэх боловсролын бодит зорилго болгон томьёолох нь сургуулийн удирдлага, багш, суралцагч зэрэг оролцогч талууд юуг илүү чухал гэж үзэж байгааг эмпирик мэдээллээр тодруулах шаардлагатай.

Иймд энэхүү судалгаагаар суралцагчдын үнэт зүйлсийг таван бүлэгт ангилан, тэдгээрийн ач холбогдлын үнэлгээ, дэд үзүүлэлтүүдийн эрэмбэ болон хэмжүүрийн найдвартай байдлыг тодорхойллоо.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

“Үнэт зүйл” ухагдахууны мөн чанар, үэнт зүйлийн талаар өмнө хийгдсэн судалгаануудыг задлан шинжиллээ. Үнэт зүйл нь “улс, үндэстний түүхэн хувьсал, хөгжлийн явцад бүтээн бий болгосон, өвлөж, хөгжүүлж байх ёстой оюун, сэтгэлийн болон эдийн дээд эрхэмлэлт зүйлийн цогц бөгөөд хүмүүс үндэснийхээ үнэт зүйлд үнэмшиж итгэдэг, зан үйл, сурч боловсрохдоо сэдэл, удирдлага болгодог онцлогтой”, “аливаа улс, үндэстний үнэт зүйл гэдэг нь тэдний түүхэн хувьсал, хөгжлийнхөө явцад бүтээн бий болгосон, өвлөж, хөгжүүлж байх ёстой оюун, сэтгэлийн болон эдийн дээд эрхэмлэлт зүйлийн цогц” (Пүрэв, 2021. т.14) гэж үзсэн байна. “Сонгодог философи болон үнэт зүйлийг судалдаг аксиологийн онолд субъектээс объектод хандсан харилцаа, түүнээс үүдсэн хэм хэмжээт үйлийн цогцыг үнэт зүйл” гэж (Оюунцэцэг .,ба бусад. 2020) тодорхойлсон. Ц.Гомбосүрэн (2004) үнэт зүйл нь “хүний оршихуйн үндэс, объектив ахуйн шаардлагын илрэлийг хүн төрөлхтний оюун ухаанаар үнэлсэн үнэлэмжийн нийлбэр” гэж дүгнэсэн бол Н.Бэгз (2018) хүний амьдралын баримжаа болж буй эрхэмлэн дээдэлдэг, чухал ач холбогдолтой зүйлсийн талаарх итгэл үнэмшлийг үнэт зүйл гэж тодорхойлжээ. Хүмүүс нийтээр хүлээн зөвшөөрдөг, үйл хөдлөлдөө дагаж мөрддөг нийтлэг жишгүүд байдаг бөгөөд чухам тэдгээрийг үнэт зүйлс буюу эрхэмлэх зүйлс гэнэ. Эрхэмлэх, дээдлэх, ёс гэдэг үг хүмүүс зан үйлдээ удирдлага болгодог эрхэм дээд үзэл санаа, итгэл үнэмшил тогтсон жишгүүд байдгийг зааж байна (Даш-Ёндон, 2008. т.109-110).

“Үнэт зүйл нь ямар ч тохиолдолд өөрчлөгдөшгүй тогтсон, бие хүний хувьд болон нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшлүүдийн цогц” гэж (McGuire, Garavan, Saha, & O'Donnell, 2006) тайлбарлажээ. Эдуард Спрангер бие хүнд институцийн, нийгмийн, улс төрийн, онолын, итгэл бишрэлийн, гоозүйн, эдийн засгийн үнэт зүйлд суурилсан өөрийн гэсэн үнэт зүйлийн бүрдэл байдаг (Erdagon & Ali, 2013) гэж үзжээ.

Монголын эрдэмтдийн үнэт зүйлсийн судалгааны чиг хандлага

Монгол Улсад 1990-ээд оноос хойш үнэт зүйл, үнэлэмжийг философи, социологи, боловсрол, соёл судлалын хүрээнд судалж ирсэн. Эдгээр судалгаанд уламжлалт үнэт зүйл, Монголчуудын үнэлэмжийн философийн үндэс, боловсрол дахь суралцахуйн үнэт зүйл, соёлын бодлого ба үнэт зүйлийн уялдаа, гэр бүлийн харилцаа, ёс суртахуун, үндэсний соёл, нийгмийн өөрчлөлтийн нөлөө, монгол хүний ижилсэл зэрэг асуудал давамгай байр суурь эзэлдэг.

ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс 1990-1999 онд хийсэн нийгмийн өөрчлөлтийн судалгаанууд шилжилтийн үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл нь хүмүүсийн амьдралын хэв маяг, үнэт зүйлийн тогтолцоонд нөлөөлж байгааг тэмдэглэсэн (ШУА, Философи, социологи, эрхийн хүрээлэн, 2001). Санхүү, эдийн засгийн их сургуулийн (2015) хийсэн “Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгаа”-нд 4214 иргэнийг хамруулж, Hofstede-ийн аргачлалд тулгуурлан үндэсний соёлын зургаан хэмжүүрийг авч үзсэн. Тус судалгаанд гэр бүлийн хүрээнд хамтач шинж давамгай боловч ажлын орчинд илүү бодгальч хандлага илэрч болохыг тэмдэглэсэн. Удирдлагын академийн хэрэгжүүлсэн “Монголчуудын үнэт зүйлсийг Шварцын аргачлалаар тодорхойлсон нь” (2017) судалгаанд 21 аймаг, нийслэлийн 796 оролцогчийг хамруулж, монголчуудын сэдэл, хандлага, үнэт зүйлийн харилцан хамаарлыг авч үзсэн. Соёл, урлагийн их сургуулийн 2018-2019 онд хийсэн үндэсний хэмжээний социологийн судалгаанд 1500 гаруй иргэнийг хамруулж, төр, монгол хүн, өв соёл, ёс суртахуун зэрэг ойлголтыг монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлтэй холбон тодорхойлсон.

Эдгээр судалгаанаас гадна суралцагчийн чадамж, суралцахуйн үнэт зүйлийг боловсролын зорилготой уялдуулан авч үзсэн дараах судалгаанууд хийгдсэн байна. Үүнд:

Боловсролын хүрээлэнгийн “XXI зууны Монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь” (2021) судалгаанд үнэт зүйлс бүрэлдэхэд нийгмийн макро орчин болон хувь хүний дотоод хүчин зүйлсийн аль аль нь нөлөөлдөг гэж үзсэн. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн “Монгол үндэсний болон монгол хүний үнэт зүйлсийг тодорхойлох” (2022) суурь судалгаанд Монгол үндэсний үнэт зүйлсийн бүрдэл, тогтолцоо, монгол хүний язгуур үнэт зүйлсийг тодотгож, эдгээрийн цөм нь Монголчуудын үндэсний ялгарал, нэгдэл-ижилсэл буюу Монголчуудыг гадаад байдлаар бусад улс, үндэстнээс ялгаруулж буй, дотооддоо биднийг ижилсүүлж, нягтруулж, нэгдмэл, иргэнлэг болгож байгаа үнэт зүйлс болох төр, газар нутаг, удам угсаа, түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн сонгодог мал аж ахуй хийгээд бусад язгуур үнэт зүйлийн цогц гэдгийг дэвшүүлсэн.

Дээрх судалгаанууд нь монголчуудын нийтлэг болон үндэсний үнэт зүйлсийн талаар чухал суурь мэдээлэл өгсөн хэдий ч сургуулийн удирдлага, багш, суралцагчдыг хамруулж, үнэт зүйлсийн ач холбогдлыг хэмжилтийн найдвартай байдлын хамт тодорхойлсон судалгаа хязгаарлагдмал байна. Энэхүү судалгаа нь энэ орон зайд чиглэж, суралцагчдын 25 үнэт зүйлийг таван бүлгээр авч үзэв.

Гадаадын эрдэмтдийн үнэт зүйлсийн судалгааны чиг хандлага

Дэлхийн улс орнууд үндэстэн, угсаатныхаа үнэт зүйлийг судлан тогтоож оршин тогтнох, хөгжих, нэгдмэл үндэстэн байх гол зүйлээ болгож байна. Тухайлбал, Финландын Хельсинкийн их сургуулийн багш Анна Уитто, Сеппо Салоранта нар Финландын IX ангийн суралцагчдын (N = 2367) үнэт зүйл, хандлага, сонирхол, урам зоригийн харилцан хамаарлыг судалсан бөгөөд хүмүүн төвт үнэт зүйл, байгаль төвт үнэт зүйл, байгальд ээлтэй болон нийгмийн хариуцлагатай хандлага, сонирхол, урам зориг нь хоорондоо нягт холбоотой болохыг тогтоосон.

Анна К. Дёринг, Эмма Жонс, Томас П. Оешгер, Елена Макарова нар үнэт зүйлсийг сургуулийн орчны бүх хүрээнд, олон янзын аргаар сурталчилдаг гэсэн үзэл бодлыг дэмжсэн ба сургуулийн уур амьсгал, захирлын манлайлал эсвэл алсын хараа нь сургуулийн орчинд үнэт зүйлс хэрхэн хүлээн явагдаж, төлөвшиж буйд (Drakenberg & Malmgren, 2013) хэрхэн нөлөөлдгийг, ялангуяа сургуулийн хамт олны бүх гишүүдийн дэмжлэгийг авахад ямар үүрэгтэйг судалсан байна.

Филиппин улсын Төв Висаяс бүс дэх нэгжид 2024-2025 оны хичээлийн жилд үнэт зүйлсэд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй түвшнийг судалж, үнэт зүйлсийг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах үндэслэлийг бүрдүүлэхийг зорьсон байна Anderson T. Peregrino (2026).

Турк улсын шинэ үндэсний сургалтын хүрээ болох Türkiye Century Maarif Model (TYMM)-д үнэт зүйлийн боловсролыг хэрхэн ойлгож, хэрэгжүүлж байгааг судалсан бөгөөд үр дүн нь үнэт зүйлсийг зөвхөн далд ёс суртахууны зарчим байдлаар биш, харин чадвар, сургалтын үйл явц, үнэлгээний шаардлагад нэгтгэсэн тодорхой сургалтын үр дүн болгон авч үздэгийг харуулсан. Мөн ёс суртахуун, үнэт зүйл, үйлдлийг холбосон нэгдмэл хүрээг онцолж, зан төлөвийн боловсролыг илүү системтэй, хэмжигдэхүйц болгох хандлагыг илэрхийлж байна (Ethem Gürhan, 2026).

Сургалтын агуулгаар эзэмшүүлэх үнэт зүйлийг үнэ цэнэ (эх хэл, түүх соёл, амь амьдрал, газар нутаг зэрэг) гэж авч үзэхээс гадна боловсролын зорилго болгон суралцагчдад төлөвшүүлэх үнэт зүйлийг хувийн болон нийгмийн бүхий л хүрээнд шийдвэр гаргахдаа баримтлах үнэлэмж, итгэл үнэмшил гэсэн өнцгөөс түлхүү авч үзэх шаардлагатай гэж үзэв.

АРГА ЗҮЙ

Өгөгдөл цуглуулах арга

Судалгаанд тоон судалгааны аргыг ашигласан. Мэдээлэл цуглуулахдаа олон нийтийн дунд нээлттэй асуулгыг Google Form цахимаар илгээсэн ба оролцогчдын хамгийн их санал нийлсэн 25 үнэт зүйлсийг сонгон авсан. Тэдгээр 25 үнэт зүйлсийг таван бүлэгт ангилсан. Үүнд: “Асуудал шийдвэрлэгч” (4 үзүүлэлт), “Тасралтгүй суралцагч” (5 үзүүлэлт), “Идэвхтэй хамтрагч” (6 үзүүлэлт), “Хүнлэг иргэн” (5 үзүүлэлт), “Соёлын өв тээгч” (5 үзүүлэлт) багтсан. Судалгаанд оролцогчдоос Лайкертийн 5 хэмжээс болох “5=хамгийн чухал”, “4=чухал”, “3=дунд зэрэг”, “2=чухал биш”, “1=огт чухал биш” гэсэн үнэлгээний хуваарь өгч эрэмбэлүүлсэн.

Өгөгдөл боловсруулах арга

Цуглуулсан мэдээллийг SPSS.21 программаар боловсруулж, дундаж, стандарт хазайлт, дотоод нийцлийн Кронбахын альфа болон баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээг (CFA) хийсэн. Судалгааны түүврийн хамгийн бага хэмжээг эх олонлогийн тоонд үндэслэн, статистикийн ач холбогдлын түвшин $\alpha = 0.05$ буюу 95.0 хувийн итгэлцлийн түвшин, 5.0 хувийн алдааны хязгаарт Кохраны томьёогоор тооцоолов.

Боловсролын яамны 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл болон удирдах ажилтны тоонд үндэслэн нийт 900 удирдах ажилтан, 37 770 багш, 797 905 суралцагчийг эх олонлогоор авч үзсэн. Тооцооллоор хамгийн бага түүврийн хэмжээ удирдах ажилтны бүлэгт 270, багшийн бүлэгт 381, суралцагчдын бүлэгт 384 буюу нийт 1 035 оролцогч байхаар тодорхойлогдов. Судалгаанд 438 удирдах ажилтан, 871 багш, 1 323 суралцагч буюу нийт 2 632 оролцогч хамрагдсан нь бүлэг тус бүрийн түүврийн хэмжээний статистикийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын түүвэр

Оролцогчдын бүлэг	Тоо	Хувь (%)
Сургуулийн удирдах ажилтан	438	16.6
Багш	871	33.1
Суралцагч	1323	50.3

Хүснэгт 1-ээс судалгаанд оролцогчдын 50.3 хувийг суралцагч эзэлж байгаа нь бидний судалгааны зорилготой нийцэж байгаа бөгөөд тэдний ямар үнэт зүйлийг чухал гэж үзэж буйг тодруулах нь чухал ач холбогдолтой гэж үзсэн.

Энэ судалгаанд бүлгийн дундаж үнэлгээнээс гадна 25 үзүүлэлт тус бүрийн дунджийг харьцуулан авч үзсэн. Үзүүлэлт болон бүлэг тус бүрийн дундаж (M), стандарт хазайлт (SD)-ыг тооцож, хэмжүүрийн дотоод нийцлийг Кронбахын альфа (α) коэффициентээр үнэлсэн. Нийт үнэлгээний тархалтын хэвийн байдлыг Колмогоров-Смирнов болон Шапиро-Уилкын сорилоор шалгасан. Нийт 25 үзүүлэлтийн таван хүчин зүйлийн онолын бүтцийг 2632 оролцогчийн өгөгдөл дээр maximum likelihood (ML) үнэлэгч ашиглан баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээгээр (CFA) шалгав. Загварын тохирлыг χ^2, CFI, TLI, RMSEA, SRMR үзүүлэлтээр үнэлж, стандартчилсан фактор ачаалал, нийлмэл найдвартай байдал (CR), дундаж тайлбарлагдсан вариац (AVE)-ыг тооцсон.

ҮР ДҮН

Ш.Шварцын үнэт зүйлийн онол:

Хүний үнэт зүйлийг бүх нийтийн 10 үндсэн хэв шинжид хувааж, тэдгээрийн сэдэл, зөрчилдөөнийг тайлбарладаг. Энэ нь үнэт зүйлийг хэмжих гол суурь болдог. Олон улсад үнэт зүйлийг Ш.Шварц (1992) нарын боловсруулсан “Schwartz's Value Survey”, Г. Хофстедийн (1978) Соёлын онол, Хаус нарын (2004) боловсруулсан “Globe” аргачлал, Р.Инглехарт нарын боловсруулсан “World Value Survey WWS” (1981) аргачлалыг ашиглан судалж байна.

Эдгээрээс Ш.Шварцын үнэт зүйлийн SVS аргачлалаар 2011 онд Европын Холбооны 20 орон, 2008 онд 28 орон, 2004 онд 27 орон, 2006 онд 41 орон, 2007 онд 72 орон, 2007-2006 онд 34, 51 оронд харьцуулсан судалгааг хийж байжээ. Тиймээс шинжлэх ухааны, найдвартай байдал олон удаа шалгагдсан, нийгэм соёлын өөр өөр орчин нөхцөл бүхий улс орнууд, улс үндэстэн, хувь хүний үнэт зүйлийг судлахад хэрэглэж байгаа зэрэг үндэслэлээр сонгон авсан.

Суралцагчдын үнэт зүйлс

Судалгаагаар тодорхойлсон таван бүлэг үнэт зүйлс нь суралцагчийн хувь хүний хөгжил, нийгэмшихүй, иргэний оролцоо, тасралтгүй суралцах хандлага болон үндэсний ижилсэлтэй холбоотой, ялгаатай боловч харилцан нөхөх чиглэлүүдийг илэрхийлнэ.



Зураг 1. Суралцагчдын үнэт зүйлсийн бүлгүүд ба 25 дэд үзүүлэлт

Эдгээр бүлгийн ялгааг тэдгээрийн дэд үзүүлэлт болон практик жишээгээр тайлбарлав. Үүнд:

- “Асуудал шийдвэрлэгч” бүлэг нь амьдрах ухаан, мэдлэгт суурилсан ертөнцийг үзэх үзэл, шинжлэх ухааны ололт амжилтыг үнэлэх, бусдын итгэл үнэмшилд нээлттэй байх зэрэг үзүүлэлтийг багтаасан. Энэ бүлэг нь өдөр тутмын болон нийгмийн асуудлыг мэдлэг, нотолгоо, туршлагаа ашиглан шийдвэрлэх хандлагыг илэрхийлнэ.

- “Тасралтгүй суралцагч” бүлэг нь бие даах байдал, өөрийгөө танин мэдэхүй, байгаль орчноо хайрлан хамгаалах, тогтвортой хөгжил, оролцоо гэсэн үзүүлэлтүүдээс бүрдсэн. Энэ бүлэг нь суралцагч өөрийн суралцах үйл явцыг хариуцан удирдах, насан туршдаа суралцах, байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжилд хариуцлагатай хандах чиглэлийг илэрхийлнэ.
- “Идэвхтэй хамтрагч” бүлэг нь эх орон, шударга ёс, хувийн болон нийгмийн хариуцлага, тэгш байдал, хүний эрх, ардчилал гэсэн үзүүлэлтийг хамарсан. Энэ бүлэг нь суралцагчийн хамтын оролцоо, иргэний хариуцлага, нийгмийн шударга ёсны талаарх хандлагыг илэрхийлнэ.
- “Хүнлэг иргэн” бүлэг нь гэр бүл, эрүүл мэнд ба сайн сайхан байдал, хүлээцтэй байдал, хүндэтгэл, хүний нэр төр гэсэн үзүүлэлтээс бүрдсэн бөгөөд таван бүлгээс хамгийн өндөр үнэлгээтэй байв. Энэ нь бусдыг хайрлах, хүндэтгэх, хүнлэг, ёс зүйтэй харилцах үнэт зүйлсийг оролцогчид онцгой чухалчилсныг харуулна.
- “Соёлын өв тээгч” бүлэг нь үндэсний бахархал ба эв нэгдэл, монгол соёл, ёс заншил, монголчуудын түүх, уламжлал, соёлын олон талт байдал, дэлхийн соёл гэсэн үзүүлэлтүүдийг багтаасан. Энэ бүлэг нь суралцагчийн үндэсний ижилсэл, өөрийн соёлын өвөө үнэлэхийн зэрэгцээ бусад соёлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагыг илэрхийлнэ.

Эдгээр таван бүлэг үнэт зүйл нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд суралцагчийг нийгэм-сэтгэл хөдлөлийн болон амьдрах ур чадвартай, үндэсний соёлоо дээдэлсэн бие хүн болж төлөвшихөд чиглэгддэг.

Хүснэгт 2. Таван бүлгийн үнэлгээ ба дотоод нийцэл

Үнэт зүйлийн бүлэг	Үзүүлэлтийн тоо	M	SD	α
Асуудал шийдвэрлэгч	4	3.74	0.62	0.705
Тасралтгүй суралцагч	5	4.04	0.65	0.851
Идэвхтэй хамтрагч	6	3.91	0.68	0.871
Хүнлэг иргэн	5	4.15	0.66	0.870
Соёлын өв тээгч	5	4.00	0.76	0.903
Нийт хэмжүүр	**25**	**3.968**	**0.56**	**0.948**

Хүснэгт 2-т үнэт зүйлсийн үнэлгээний нийт дундаж 3.968 байгаа бөгөөд санал болгосон үнэт зүйлсийг оролцогчид нийтэд нь чухал, маш чухал түвшинд үнэлснийг харуулж байна. Бүлгүүдээс “хүнлэг иргэн” хамгийн өндөр (M=4.15), дараа нь “тасралтгүй суралцагч” (M=4.04), “соёлын өв тээгч” (M=4.00), “идэвхтэй хамтрагч” (M=3.91) орсон бол “асуудал шийдвэрлэгч” (M=3.74) харьцангуй доогуур үнэлгээтэй байна. Хэмжүүрийн дотоод нийцлийн коэффициент нийт түвшинд α=.948 байв. Бүлгүүдийн коэффициент α=.705-.903-ийн хооронд хэлбэлзэж, “соёлын өв тээгч” бүлэг α=.903, “асуудал шийдвэрлэгч” бүлэг α=.705 үзүүлэлттэй гарсан.

Үнэт зүйлсийг бүлгээр тодорхойлохоос гадна бүлэг бүрийн дэд үзүүлэлтээр үр дүнг нэгтгэн Хүснэгт 3-д харууллаа.

Хүснэгт 3. Таван бүлэг дэх үнэт зүйлсийн үнэлгээ

Бүлэг	Дэд үзүүлэлт	M	SD
Асуудал шийдвэрлэгч	Шинжлэх ухааны ололт амжилт	3.46	0.849
	Мэдлэгт суурилсан ертөнцийг үзэх үзэл	3.63	0.775
	Бусдын итгэл үнэмшилд нээлттэй байх	3.48	0.805
Тасралтгүй суралцагч	Амьдрах ухаан	4.34	0.698
	Оролцоо	3.97	0.798
	Тогтвортой хөгжил	3.89	0.788
	Байгаль орчноо хайрлан хамгаалах	4.14	0.744
	Өөрийгөө танин мэдэхүй	4.20	0.722
Идэвхтэй хамтрагч	Бие даах байдал	4.30	0.696
	Хувийн болон нийгмийн хариуцлага	3.98	0.810
	Хүний эрх	3.78	0.820
	Ардчилал	3.41	0.887

	Тэгш байдал	3.86	0.812
	Эх орон	4.23	0.775
	Шударга ёс	4.23	0.754
	Хүний нэр төр	3.82	0.850
	Эрүүл мэнд, сайн сайхан байдал	4.30	0.765
Хүнлэг иргэн	Хүндэтгэл	3.98	0.746
	Гэр бүл	4.34	0.723
	Хүлээцтэй байдал	3.98	0.764
	Монгол соёл, ёс заншил	4.14	0.847
Соёлын өв тээгч	Монголчуудын түүх, уламжлал	4.08	0.834
	Соёлын олон талт байдал	3.71	0.843
	Үндэсний бахархал, эв нэгдэл	4.22	0.828
	Дэлхийн соёл	3.59	0.829

Эндээс үзэхэд 25 дэд үзүүлэлтийг харьцуулахад “гэр бүл” (M=4.34, SD=.723) болон “амьдрах ухаан” (M=4.34, SD=.698) хамгийн өндөр үнэлэгдэв. Үүний дараа “бие даах байдал” (M=4.30, SD=.696), “эрүүл мэнд, сайн сайхан байдал” (M=4.30, SD=.765), “эх орон” (M=4.23, SD=.775), “шударга ёс” (M=4.23, SD=.754), “үндэсний бахархал, эв нэгдэл” (M=4.22, SD=.828), “өөрийгөө танин мэдэхүй” (M=4.20, SD=.722) өндөр үнэлгээтэй байна.

Харин харьцангуй доогуур үнэлэгдсэн үзүүлэлтүүдэд “ардчилал” (M=3.41), “шинжлэх ухааны ололт амжилт” (M=3.46), “бусдын итгэл үнэмшилд нээлттэй байх” (M=3.48), “дэлхийн соёл” (M=3.59), “мэдлэгт суурилсан ертөнцийг үзэх үзэл” (M=3.63) багтав. Эдгээр үзүүлэлт 3.0-аас дээш дундажтай бөгөөд бусад үзүүлэлттэй харьцуулахад доогуур эрэмбэлэгдсэн байна.

Нийт үнэлгээний тархалтын хэвийн байдлыг шалгахад Колмогоров-Смирновын сорил D=.036, p=.001, Шапиро-Уилкын сорил W=.983, p=.001 гарсан.



Зураг 2. Нийт үнэт зүйлийн үнэлгээний тархалт

Иймд хэвийн тархалтын тэг таамаглал няцаагдав. Гистограммын дүрслэлээр үнэлгээ 4.0 орчимд төвлөрсөн тархалттай байна.

Хүснэгт 4. Нийт үнэлгээний тархалтын хэвийн байдлын сорил

Сорил	Статистик	df	p
Колмогоров-Смирнов	0.036	2632	0.001
Шапиро-Уилк	0.983	2632	0.001

Баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээ (CFA)

Стандартчилсан фактор ачаалал, үлдэгдэл вариац, CR, AVE болон хүчин зүйлсийн хоорондын корреляцийг Зураг 3-д үзүүлэв.



Зураг 3. 25 үнэт зүйлийн хэмжүүрийн 5 хүчин зүйлийн CFA загвар (N=2632)

Таван хүчин зүйлийн онолын загварыг нийт түүвэрт (N=2632) CFA-аар шалгахад $\chi^2(265)=3743.21$, $p<.001$, CFI=.912, TLI=.900, RMSEA=.071 (90% CI [.069, .073]), SRMR=.044 байв.

Загварын тохирлын 25 үзүүлэлтээс бүрдэх таван хүчин зүйлийн хэмжил зүйн бүтцийг нийт түүврийн өгөгдөл дэмжиж байгааг харууллаа. Стандартчилсан фактор ачаалал λ=.520-.898-ийн хооронд хэлбэлзэж, бүх үзүүлэлт өөрийн харьяалах хүчин зүйлдээ .50-аас дээш ачаалалтай байна. Хэмжүүрийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх хүрээнд хүчин зүйл тус бүрийн нийлмэл найдвартай байдлын коэффициент (CR)-ийг тооцоход .698-.906-ийн хооронд байгаа нь хэмжилтийн найдвартай байдал ерөнхийдөө хангалттай түвшинд байв. Таван хүчин зүйлээс дөрөв нь CR ≥ .70 гэсэн зөвлөмжит шалгуурыг хангасан бол “асуудал шийдвэрлэгч” хүчин зүйлийн CR = .698 нь уг босгод ойролцоо байна. Энэхүү үр дүн нь хүчин зүйл тус бүрд хамаарах үзүүлэлтүүд хоорондоо уялдаатай, хэмжилтийн найдвартай байдал хангагдаж байгааг харуулж, хэмжүүрийн бүтцийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэхэд дэмжих нотолгоо болж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгааны үр дүнгээс “хүнлэг иргэн” бүлэг хамгийн өндөр үнэлэгдсэн нь суралцагчийн төлөвшилд гэр бүл, эрүүл мэнд, сайн сайхан байдал, хүндэтгэл, хүлээцтэй байдал, хүний нэр төр зэрэг хүн хооронд харилцаа, ёс зүйтэй холбоотой үнэт зүйлс чухал байр суурь эзэлж байгааг харууллаа. Ялангуяа “гэр бүл” үзүүлэлт нийт 25 үзүүлэлтээс хамгийн өндөр дундажтай гарсан нь монгол улсад хийгдсэн өмнөх судалгаануудад гэр бүлийн харилцаа, ёс суртахууны үнэлэмжийг тогтвортой чухалчилсан үр дүнтэй (СЭЗИС, 2015; СУИС, 2019) ерөнхийдөө нийцэж байна.

“Тасралтгүй суралцагч” бүлэг хоёрдугаарт үнэлэгдэж, “Бие даах байдал”, “өөрийгөө танин мэдэхүй”, “Байгаль орчноо хайрлан хамгаалах” үзүүлэлтүүд өндөр үнэлгээтэй гарсан нь суралцагчийн хөгжилд өөрийгөө удирдах, өөрийн суралцах үйл явцад хариуцлага хүлээх, байгаль орчинд ээлтэй хандахыг оролцогчид чухал гэж үзэж байгааг харуулна. Энэ нь суралцахуйг зөвхөн академик амжилтаар хязгаарлах бус, хувь хүний бие даасан хөгжил, тогтвортой хөгжлийн хариуцлагатай холбон авч үзэх шаардлагатайг илтгэнэ.

“Соёлын өв тээгч” бүлгийн дотор “Үндэсний бахархал, эв нэгдэл”, “Монгол соёл, ёс заншил”, “Монголчуудын түүх, уламжлал” өндөр үнэлэгдсэн нь 2022 оны үндэсний үнэт зүйлийн суурь судалгаанд онцолсон үндэсний ялгарал, нэгдэл-ижилслийн үнэт зүйлтэй уялдаж байна. Харин “Соёлын олон талт байдал”, “Дэлхийн соёл” харьцангуй доогуур эрэмбэлэгдсэн нь үндэсний соёлоо дээдлэх болон дэлхийн соёлын олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх хоёр чиглэлийг сургалтын хөтөлбөрт харилцан нөхөх байдлаар тусгах хэрэгцээг харуулж байна (БСҮХ, 2022).

“Идэвхтэй хамтрагч” бүлгийн хувьд “Эх орон” болон “Шударга ёс” өндөр үнэлэгдсэн боловч “Ардчилал”, “Хүний эрх”, “Тэгш байдал” харьцангуй доогуур эрэмбэтэй гарсан. Эдгээр үзүүлэлтүүдийн дундаж 3-аас дээш тул ач холбогдолгүй гэсэн утгаар тайлбарлах үндэсгүй. Харин суралцагчийн иргэний оролцоо, хүний эрх, тэгш байдлын талаарх ойлголтыг зөвхөн онолын агуулгаар бус, сургуулийн өдөр тутмын хамтын шийдвэр гаргалт, дүрэм журам, харилцаа, оролцооны бодит нөхцөлтэй холбон төлөвшүүлэх шаардлагатай байна.

“Асуудал шийдвэрлэгч” бүлэг таван бүлгээс хамгийн бага дундажтай байсан ч “Амьдрах ухаан” үзүүлэлт хамгийн өндөр үнэлэгдсэн нь энэ бүлгийн дотор ач холбогдлын ялгаа байгааг харуулна. “Шинжлэх ухааны ололт амжилт”, “Мэдлэгт суурилсан ертөнцийг үзэх үзэл”, “Бусдын итгэл үнэмшилд нээлттэй байх” үзүүлэлтүүдийн харьцангуй доогуур үнэлгээ нь амьдралын практик асуудлыг шийдвэрлэх чадварыг нотолгоонд суурилсан сэтгэлгээ, шинжлэх ухааны хандлага, өөр үзэл бодлыг сонсох чадвартай илүү тодорхой уялдуулах шаардлагатайг харуулж болно.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАЛТ

Энэхүү судалгаа нь оролцогчдын үнэт зүйлсийн талаарх үнэлгээнд тулгуурласан бөгөөд суралцагчийн бодит зан үйл, сургуулийн өдөр тутмын практикийг шууд хэмжээгүй бөгөөд зөвхөн асуулгын аргаар цуглуулсан мэдээллийн үр дүнг нэгтгэсэн болно.

ДҮГНЭЛТ

1. Судалгаанд хамрагдсан 2632 оролцогч суралцагчдад төлөвшүүлэх 25 үнэт зүйлсийг нийтэд нь өндөр ач холбогдолтой гэж үнэлсэн бөгөөд таван бүлгээс “Хүнлэг иргэн”, “Тасралтгүй суралцагч”, “Соёлын өв тээгч” хамгийн өндөр үнэлгээтэй байсан бөгөөд дэд үзүүлэлтээс гэр бүл, амьдрах ухаан, бие даах байдал, эрүүл мэнд ба сайн сайхан байдал, эхорон, шударга ёс, үндэсний бахархал ба эв нэгдэл эрэмбийг тэргүүлж байна.
2. Судалгааны үр дүн нь суралцагчдын үнэт зүйлсийг үндэсний уламжлал, түүх, соёлын хүрээнд хязгаарлах бус, хүнлэг чанар, бие даан суралцах хандлага, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжил, шинжлэх ухааны сэтгэлгээ, дэлхийн соёлын олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх чадамжтай цогцоор нь авч үзэх шаардлагатайг харуулж байна.
3. Сургалтын хөтөлбөрт үнэт зүйлсийг ерөнхий тунхаглал байдлаар оруулахаас илүүтэй хичээл, судлагдахууны суралцахуйн үр дүн, сургалтын үйл ажиллагаа, үнэлгээ, сургуулийн соёл, суралцагчийн өдөр тутмын оролцоотой уялдуулан тодорхойлох нь зүйтэй. CFA-ийн үр дүн нь 25 үзүүлэлтийн таван хүчин зүйлийн онолын зохион байгуулалтыг нийт түүвэрт дэмжсэн бөгөөд

суралцагчдад төлөвшүүлэх үнэт зүйлсийг хэмжихэд энэхүү бүтцийг ашиглах эмпирик үндэслэлийг нэмэгдүүлж байна.

Цаашид оролцогч талуудын бүлэг хоорондын ялгаа болон хэмжилтийн инвариант байдлыг олон бүлгийн CFA-аар шинжилснээр хэмжүүрийн хэрэглээний хүрээг улам нарийвчлах боломжтой.

ТАЛАРХАЛ

Энэхүү өгүүллийг бичихэд онол, арга зүйн үнэтэй зөвлөгөө өгч, хамтран ажилласан МУИС-ийн багш М. Итгэл, БСҮХ-ийн захирал Х. Отгонбаатар нар болон судалгаанд оролцож, мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлсэн нийт оролцогчдод талархал илэрхийлье.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: М.И., Х.О., Г.Б., Х.Э; арга зүй: Х.Э., М.И.; мэдээлэл цуглуулалт: Х.Э., С.Ц., Б.Б.; эхний хувилбарын бичилт: Х.Э.; засвар, сайжруулалт: Х.Э., Б.Б.; мэргэжлийн удирдлага: М.И., Г.Б.

НОМ ЗҮЙ

Баатартогтох, Ц. (2000). Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал [Докторын диссертаци].

Боловсролын хүрээлэн. (2021). XXI зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь [Судалгааны тайлан].

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн. (2022). Монгол үндэсний болон монгол хүний үнэт зүйлсийг тодорхойлох: Суурь судалгааны тайлан. Боловсрол, шинжлэх ухааны яам.

Долгорсүрэн, Ж. (2019). Монголчуудын үнэт зүйлсэд нөлөөлж буй хүчин зүйл. Монгол соёл урлаг судлал, XXXI, 32–47.

Монгол Улсын Засгийн газар. (2024, 4-р сарын 24). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024–2036) (Засгийн газрын 176 дугаар тогтоолын хавсралт). Legalinfo. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353233251

Монгол Улсын Их Хурал. (2023, 7-р сарын 7). Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга). Legalinfo. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301

Оюунцэцэг, Н., Норжхорлоо, Н., & Сарангэрэл, Д. (2019). 21 дүгээр зууны монгол суралцагч боловсролоос юу хүсэн хүлээх вэ? Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг, 24, 229–238.

Оюунцэцэг, Н., Норжхорлоо, Н., Сарангэрэл, Д., & Энхтогтох, А. (2020). Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй.

Пүрэв, О. (2019). Боловсролын хүн судлал хийгээд монгол хүний суралцах үнэт зүйлийн судалгаа. Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг, 24.

Санхүү, эдийн засгийн их сургууль. (2015). Монголын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан.

Соёл, урлагийн их сургууль. (2019). Монголчуудын үнэт зүйл: Социологийн судалгааны дүн [Судалгааны тайлан].

Удирдлагын академи. (2017). Монголчуудын үнэт зүйлсийг Шварцын аргачлалаар тодорхойлсон нь [Судалгааны тайлан].

Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. (2001). Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн өөрчлөлт.

Чулуунбаатар, Г., & Сонинтогос, Э. (2018). Монгол төрийн соёлын бодлого ба үнэт зүйлийн судалгаа. In Монголчуудын соёлын ертөнц, үнэт зүйл, өв, урлаг: Олон улсын монгол эрдэмтний хурлын эмхэтгэл.

Barrett, R. (2006). Building a values-driven organization: A whole system approach to cultural transformation. Elsevier.

Hofstede, G., Hofstede, G. J., & Minkov, M. (2010). Cultures and organizations: Software of the mind (3rd ed.). McGraw-Hill.

OECD. (2021). Embedding values and attitudes in curriculum: Shaping a better future. OECD Publishing. https://doi.org/10.1787/aee2adcd-en

okeach, M. (1973). The nature of human values. Free Press.

Schwartz, S. H. (1992). Universals in the content and structure of values: Theoretical advances and empirical tests in 20 countries. Advances in Experimental Social Psychology, 25, 1–65. https://doi.org/10.1016/S0065-2601(08)60281-6

Schwartz, S. H. (2012). An overview of the Schwartz theory of basic values. Online Readings in Psychology and Culture, 2(1). https://doi.org/10.9707/2307-0919

Anna Uittoa, Seppo Salorantaa (2010). The relationship between secondary school students' environmental and human values, attitudes, interests and motivations., Departement of teacher education, PO Box 9, FIN-00014 University of Helsinki

Anna K. Döring, Emma Jones, Thomas P. Oeschger, Elena Makarova (2022). Giving voice to educators: Primary school teachers explain how they promote values to their pupils, https://doi.org/10.1007/s10212-024-00885-8Anderson T. Peregrino (2026). Analyzing the implementation of values-centric curriculum., Schools Division of Canlaon City, Negros Oriental, https://doi.org/10.56738/issn29603986.geo2026.7.162

Ethem Gürhan (2026). Values Education in Curriculum Reform: A Qualitative Document Analysis of the Türkiye Century Maarif Model for Primary Education, https://doi.org/10.70376/jerp.v4i1.413

Зохиогчдын мэдээлэл

Халтар овогтой Энхжаргал
https://orcid.org/0000-0002-2708-8415
Байгууллагын нэр: МУБИС-ийн БоСС-ийн докторант, БСҮХ-ийн ББСС-ын эрхлэгч
Хаяг:СБД-ийн 8 дугаар хороо, Багшийн хөгжлийн ордон- 304 тоот
Улс: Монгол
e-mail: enkhjargal@mier.mn

Гомбо овогтой Баярмаа
https://orcid.org/0009-0004-8267-059X
Байгууллагын нэр: МУБИС-ийн БоСС
Хаяг: СБД-ийн 8 дугаар хороо, МУБИС-ийн VIII байр, 502 тоот
Улс: Монгол
e-mail: bayarmaa.g@msue.edu.mn

Баярсайхан овогтой Батцэнгэл
https://orcid.org/0009-0007-1057-0700
Байгууллагын нэр: БСҮХ, ББСС-ын ЭША
Хаяг: СБД-ийн 8 дугаар хороо, Багшийн хөгжлийн ордон- 304 тоот
Улс: Монгол
e-mail: battsengel@mier.mn

Сэржмядаг овогтой Оюунчимэг
https://orcid.org/0000-0002-4419-9432
Байгууллагын нэр: БСҮХ,
Хаяг: СБД-ийн 8 дугаар хороо, МУБИС-ийн VIII байр, 305 тоот
Улс: Монгол
e-mail: tsogbadrakh@gmail.com

Энхбаяр овогтой Оюунчимэг
https://orcid.org/0009-0007-1057-0700
Байгууллагын нэр: БҮТ-ийн мэргэжилтэн Хаяг: СБД-ийн 8 дугаар хороо, БҮТ-ийн байр
Улс: Монгол
e-mail: oyunchimeg@eec.mn